



ХУУЛЬ ЗҮЙН
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

ЗӨРЧИЛ ШАЛГАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛИЙН
ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВАРТ ХЭСЭГЧЛЭН
ХИЙСЭН ҮНЭЛГЭЭ

2018

СУДАЛГААНЫ ТАЙЛАН

ЗӨРЧИЛ ШАЛГАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВАРТ ХЭСЭГЧЛЭН ХИЙСЭН ҮНЭЛГЭЭ ¹

УДИРТГАЛ

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу үнэлгээ хийв.

Энэхүү үнэлгээний зорилго Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилтийн бодит байдалд дүн шинжилгээ хийж, гарч байгаа хүндрэл, бэрхшээлтэй асуудал, түүний үр дагавар зэрэгт үндэслэн санал, дүгнэлт боловсруулахад оршино.

НЭГ. ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ

1.1. Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох

Хууль зүйн үндэслэл

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “...хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна”, Арван зургадугаар зүйлийн 14 дэх хэсэгт “...эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, ...нотлох баримтыг шалгуулах, шударга шүүхээр шүүлгэх, хэргээ шүүх ажиллагаанд биеэр оролцох, шүүхийн шийдвэрийг давж заалдах эрхтэй” гэж заасан.

Хууль тогтоомжийн тухай хуульд хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг хийхдээ энэ хуульд өөрөөр заагаагүй бол хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт хийх үнэлгээг тухайн хууль тогтоомжийг дагаж мөрдсөнөөс хойш 5 жил тутамд хийх бөгөөд шаардлагатай тохиолдолд дээрх хугацаанаас өмнө хийж болно.

Практик шаардлага

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль хэрэгжиж эхэлснээр захиргааны хэргийн шүүх зөрчил хянан шийдвэрлэх ажиллагааны ерөнхий зарчим, түүнчлэн хууль сахиулагчийн хийвэл зохих зан үйлүүд буюу нарийвчилсан зан үйлүүд процесс нь энэхүү хуульд бүрэн тусгагдаж өгөөгүй зэргээс үүдэлтэйгээр хуулийг нэг мөр хэрэгжүүлэхэд хүндрэл, бэрхшээл үүсгэж байна.

1.2. Үнэлгээ хийх хүрээг тогтоох

Үнэлгээ хийх хүрээг тогтоохдоо дээрх хууль зүйн үндэслэл, практик шаардлагыг харгалзан үзэж дараах зүйл, заалтыг сонгон авсан болно. Үүнд:

Хүснэгт 1. Үнэлэх зүйл, заалт

Д/д	Сонгосон зүйл, заалт	Агуулга
1	2.1 дүгээр зүйл. Зөрчил хянан шийдвэрлэх шүүх	2.Захиргааны хэргийн шүүх энэ хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.7, 6.10, 6.11, 6.12, 6.14, 6.15, 6.16, 6.17, 6.18, 6.19, 6.20, 6.21, 6.22, 6.23, 6.24, 6.25, 6.27 дахь заалтад заасан эрх бүхий албан тушаалтны шийтгэл оногдуулсан шийдвэрт гаргасан оролцогчийн гомдол, прокурорын дүгнэлтээр зөрчил хянан шийдвэрлэнэ.

¹ Тус судалгааг хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга, хууль зүйн доктор, дэд профессор П.Амаржаргал удирдан, эрдэм шинжилгээний ажилтан У.Эрдэнэзаяа, С.Цэрэндолгор нар хамтран гүйцэтгэв.

2	4.8 дугаар зүйл. Мэдүүлэг авах	1.Эрх бүхий албан тушаалтан зөрчил гарсан байдлыг тодруулах, зөрчил шалган шийдвэрлэхэд ач холбогдол бүхий баримт, мэдээллийг олох зорилгоор мэдүүлэг авна. 2.Мэдүүлгийг тухайн хүнийг эрх бүхий байгууллагад ирүүлэн, эсхүл тухайн хүний байгаа газарт авч болно. 4.Эрх бүхий албан тушаалтан хүнийг албадан ирүүлэх, өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг /эх/, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхийг шаардах эрхгүй.
3	6.6 дугаар зүйл. Хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлэх	1.Дараахь үндэслэлийн аль нэг нь тогтоогдвол эрх бүхий албан тушаалтан зөрчлийг хялбаршуулсан журмаар шалган шийдвэрлэнэ: 1.1.зөрчил үйлдэгдсэн нь ил тодорхой, зөрчил, учирсан хохирлыг нотлох талаар зөрчлийн хэрэг бүртгэлт явуулах шаардлагагүй бол; 1.2.зөрчил үйлдэгдсэн, учруулсан хохирол нь нотлох баримтаар тогтоогдож холбогдогч зөрчил үйлдсэнээ сайн дураараа хүлээн зөвшөөрсөн бол; 1.3.зөрчил үйлдсэн болох нь стандартаар баталгаажсан хэмжилт-хяналтын төхөөрөмжөөр нотлогдсон бол. 2.Зөрчлийн хэрэг бүртгэлтийн явцад холбогдогч зөрчил үйлдсэнээ сайн дураараа хүлээн зөвшөөрсөн, эсхүл зөрчил үйлдсэн нь тогтоогдож байгаа бол эрх бүхий албан тушаалтан хуульд заасан шийтгэл оногдуулж, албадлагын арга хэмжээ авна. 3.Холбогдогчийг зөрчил үйлдсэн болохыг хүлээн зөвшөөрүүлэхээр тулган шаардах, албадахыг хориглоно. 4.Эрх бүхий албан тушаалтан хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлэж, шийтгэл оногдуулахдаа энэ хуулийн 7.1 дүгээр зүйлд заасан журмыг баримтална. 5.Эрх бүхий албан тушаалтан хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлэсэн даруй прокурорын нэгдсэн бүртгэлд бүртгүүлнэ.
4	7.6 дугаар зүйл. Шийтгэл оногдуулсан шийдвэрт гомдол гаргах	2.Оролцогч энэ хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.7, 6.10, 6.11, 6.12, 6.14, 6.15, 6.16, 6.17, 6.18, 6.19, 6.20, 6.21, 6.22, 6.23, 6.24, 6.25, 6.27 дахь заалтад заасан эрх бүхий албан тушаалтны шийтгэл оногдуулсан шийдвэрийг эс зөвшөөрвөл Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан журмаар гомдол гаргаж шийдвэрлүүлнэ.

1.3. Шалгуур үзүүлэлтийг сонгож тогтоох

Үнэлгээний шалгуур үзүүлэлтийг дараах үндэслэлээр сонгосон болно. Үүнд:

Зорилгод хүрсэн түвшин шалгуур үзүүлэлтийн хүрээнд Зөрчлийн тухай хууль батлагдсантай холбогдуулан Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийг баталж, мөрдөж эхэлсэн бөгөөд энэхүү хугацаанд хуулиар зохицуулсан харилцаа хуулийн зорилгодоо хүрч чадаж байгаа эсэх;

Практикт нийцэж байгаа байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд уг хууль хэрэгжиж эхэлснээр практикт хэр нийцэж байгаа, хэрэгжилтэд тулгарч байгаа хүндрэл, бэрхшээлийг илрүүлэхийг зорьсон болно.

1.4. Харьцуулах хэлбэрийг сонгох

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхдээ үнэлгээ хийх шалтгаан, үнэлгээний хүрээ, шалгуур үзүүлэлт зэргийг харгалзан үзсэний үндсэн дээр хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойших; хууль тогтоомж батлагдахаас өмнө болон хууль тогтоомж батлагдсанаас хойш; тохиолдол судлах хэлбэрийг сонгож үнэлгээг хийлээ.

1.5. Шалгуур үзүүлэлтийг томьёолох

Үнэлгээний шалгуур үзүүлэлтийг томьёолохдоо Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулиас сонгон авсан зүйл тус бүрийг ялгаатай байдлаар тохиромжтой шалгуур үзүүлэлтээр үнэлэхийг зорив.

Зорилгод хүрсэн түвшин шалгуур үзүүлэлтээр холбогдох зохицуулалт зорилгодоо хүрсэн эсэх, салбарын бусад хууль тогтоомж, зарчимтай уялдаж буй эсэх;

Практикт нийцэж байгаа байдал шалгуур үзүүлэлтээр холбогдох зохицуулалт хэрхэн хэрэгжиж байгаа, түүний үр дагавар, хэрэгжүүлэхэд хүндрэл гарч байгаа эсэхийг тодорхойлохыг зорьсон болно.

1.6. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох

Үнэлгээний мэдээлэл цуглуулах шатанд төрийн тусгай албан хаагчдын төлөөлөлтэй ганцаарчилсан ярилцлага хийсний зэрэгцээ харьцуулах арга, баримт бичиг судлах аргаар мэдээлэл цуглуулсан.

ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ

Үнэлгээний ажилд шаардлагатай мэдээллийг цуглуулахдаа Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд хамаарах асуудлаар тус хуулийг хэрэгжихээс өмнө болон хэрэгжиж эхэлснээс хойш нийтлэгдсэн эрдэмтэн, судлаачдын илтгэл, өгүүлэл, судалгааны тайлан, гарын авлага хийгээд бусад эх сурвалжуудыг үндэслэв. Гэвч уг хууль хэрэгжээд богино хугацаа өнгөрч байгаа тул өнөөдрийн байдлаар холбогдох нэг сэдэвт бүтээл, судалгаа ховор байсан болно.

Үнэлгээний ажилд ганцаарчилсан ярилцлага, харьцуулах арга, баримт бичгийн аргыг ашиглан хийж гүйцэтгэв.

Баримт бичгийн судалгаанд холбогдох хууль тогтоомж, журам, эрдэм шинжилгээний бүтээлийг ашигласан ба эрдэмтэн, судлаачид, Улсын ерөнхий прокурорын газар, Чингэлтэй дүүргийн прокурорын газар, Сүхбаатар дүүрэг дэх Цагдаагийн нэгдүгээр хэлтэс, Сүхбаатар дүүргийн 7, 8 дугаар хорооны цагдаагийн албан хаагчидтай экспертийн болон ганцаарчилсан ярилцлага хийх аргаар анхдагч мэдээлэл цуглуулсан.

ГУРАВ. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн хоёр, дөрөв, зургаа, долдугаар бүлгээс сонгож авсан үнэлэх зүйл, заалтыг хэрэгжүүлэх үе шатанд олж авсан мэдээлэл дээр тулгуурлан үнэлэх болно.

3.1. “Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 1. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 2.1 дүгээр зүйл буюу захиргааны хэргийн шүүхэд зарим хэргийг харьяалуулсан зохицуулалт зорилгодоо хүрч байна уу?

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 2. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 7.6 дугаар зүйл буюу шийтгэл оногдуулсан шийдвэрт гомдол гаргах зохицуулалт зорилгодоо хүрч байна уу?

Үнэлэх зүйл, заалт	2.1 дүгээр зүйл. Зөрчил хянан шийдвэрлэх шүүх 2.Захиргааны хэргийн шүүх энэ хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.7, 6.10, 6.11, 6.12, 6.14, 6.15, 6.16, 6.17, 6.18, 6.19, 6.20, 6.21, 6.22, 6.23, 6.24, 6.25, 6.27 дахь заалтад заасан эрх бүхий албан тушаалтны шийтгэл оногдуулсан шийдвэрт гаргасан оролцогчийн гомдол, прокурорын дүгнэлтээр зөрчил хянан шийдвэрлэнэ
	7.6 дугаар зүйл. Шийтгэл оногдуулсан шийдвэрт гомдол гаргах 2.Оролцогч энэ хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.7, 6.10, 6.11, 6.12, 6.14, 6.15, 6.16, 6.17, 6.18, 6.19, 6.20, 6.21, 6.22, 6.23, 6.24, 6.25, 6.27 дахь заалтад заасан эрх бүхий албан тушаалтны шийтгэл оногдуулсан шийдвэрийг эс зөвшөөрвөл Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан журмаар гомдол гаргаж шийдвэрлүүлнэ.

Үнэлгээ: Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулиар зарим хэргийг Захиргааны хэргийн шүүхэд харьяалуулсан бөгөөд зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг Эрүүгийн хэргийн шүүхээр шийдвэрлэх журмыг нарийвчлан зохицуулсан атлаа Захиргааны хэргийн шүүхэд харьяалуулсан зөрчлийг хэрхэн шийдвэрлэх талаар зохицуулаагүй, гагцхүү Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийг эш татан хуульчилсан. Өөрөөр хэлбэл, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль дахь Захиргааны хэргийн шүүхтэй холбоотой хоёр л заалт байгаа нь үнэлгээний хүрээгээр тогтоосон дээрх заалтууд юм. Эдгээр нь хоорондоо уялдаатай буюу 2.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт Захиргааны хэргийн шүүхийн харьяалан шийдвэрлэх зөрчлийн хэргийг, 7.6 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт Захиргааны хэргийн шүүх зөрчлийн хэргийг хянан шийдвэрлэхдээ Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийг хэрэглэх талаар заасан тул хамтад нь авч үзэх шаардлагатай. Иймд энэхүү заалтуудыг хамтад нь сонгож, зорилгодоо хүрсэн эсэх, салбар эрх зүйн зарчимд нийцэж буй эсэхийг тодруулахыг зорьсон болно.

а) Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль ба Захиргааны хариуцлагын тухай хууль түүнчлэн Захиргааны хэргийн шүүхэд харьяалуулсан эрх бүхий албан тушаалтны шийдвэр гаргах ажиллагаа, салбарын зарим хууль тогтоомжийн уялдаа холбоо

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль батлагдан хэрэгжиж эхлэхээс өмнө Захиргааны хариуцлагын тухай хуулиар зөрчлийг хянан шийдвэрлэж байсан бөгөөд захиргааны зөрчилд тооцогдох үйлдэл, шалган шийдвэрлэх журмыг хамтад нь тусгасан² буюу материаллаг болон процессын эрх зүйн асуудлын аль алиныг тус хуулиар зохицуулж байсан.

Захиргааны хариуцлагын тухай хуулийн 3 дугаар зүйлд “Монгол Улсын нутаг дэвсгэрт бүх нийтээр буюу тухайн нутаг дэвсгэрт дагаж мөрдүүлэхээр тогтоосон захиргааны журам санаатай буюу болгоомжгүйгээр зөрчсөн үйлдэл, эс үйлдэхгүйг захиргааны зөрчил /цаашид “зөрчил” гэх/ гэж үзнэ” хэмээн зааснаас үзвэл “захиргааны журам”-ыг зөрчсөн санаатай буюу болгоомжгүй үйлдлийг зөрчил гэж ойлгож, түүнийг “захиргааны зөрчил” гэх нэр томъёогоор илэрхийлж байжээ. Харин одоогийн Зөрчлийн тухай хууль болон Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд бүх зөрчлийг зөвхөн “зөрчил”³ гэсэн нэр томъёогоор тусгасан.

Захиргааны хариуцлагын тухай хуулийг хүчин төгөлдөр үйлчилж байх үед хийсэн судалгааны тайланд “...Захиргааны хариуцлагын хуулийн хэрэгжилт, үр

² Захиргааны хариуцлагын тухай хуулийн нэгдүгээр бүлгээр нийтлэг үндэслэл, зөрчил шалган шийдвэрлэх журмыг; хоёрдугаар бүлгээр захиргааны зөрчил, тэдгээрт хүлээлгэх хариуцлагыг зохицуулжээ. Өөрөөр хэлбэл, процессын эрх зүйн асуудлыг нэгдүгээр бүлэгт, материаллаг эрх зүйн асуудлыг хоёрдугаар бүлэгт тусгасан байна.

³ Зөрчлийн тухай хуулийн 2.1 дүгээр зүйлд “Хууль, захиргааны хэм хэмжээний актыг зөрчсөн, энэ хуульд шийтгэл оногдуулахаар заасан үйлдэл, эс үйлдэхгүйг зөрчил гэнэ” хэмээн тодорхойлжээ.

нөлөөний асуудалд нэлээдгүй бэрхшээл давхардал үүсгэдэг хууль бол Монгол Улсын Эрүүгийн хууль мөн. Учир нь Захиргааны хариуцлагын тухай хуульд заасан захиргааны зөрчил болон Эрүүгийн хууль дахь гэмт хэргийн хоорондын ялгаатай шинжийн асуудал өнөөдөр чухал сэдэв болоод байна.

...Захиргааны хариуцлагын тухай нийтлэг /ерөнхий/ хууль ба захиргааны хариуцлагын хэм хэмжээ тогтоосон бусад хууль тогтоомжийн заалтыг үзэхэд гэмт хэрэг, захиргааны зөрчлийн ялгааг "...хэрэв эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол..." гэсэн ерөнхий үг хэллэгээр заагласан нь бий. Гэвч дээрх хууль тогтоомжийн "...хэрэв эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол..." гэсэн заалтыг судлан үзэхэд гэмт хэрэг, захиргааны зөрчлийн ялгаа бараг харагдахгүй байгаа юм"⁴ гэжээ.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн танилцуулгад⁵ "Зөрчлийн тухай хуулийн төслөөр зөрчлийг гэмт хэргээс зааглан тодорхойлж, өнөөдөр Монгол Улсын нийт 230 гаруй хуульд заасан зөрчлийг хууль зүйн нэгдсэн бодлогоор цэгцлэн, нэг стандартаар төрөлжүүлэн нэгтгэсэн. Иймд зөрчил үйлдсэн этгээдэд хариуцлага оногдуулах эрх бүхий 26 албан тушаалтны шийдвэрлэх зөрчлийн харьяаллыг Зөрчлийн тухай хуулийн төсөлд заасантай нийцүүлэн тусгалаа" хэмээсэн хэдий ч харамсалтай нь, шинэчлэн найруулсан Зөрчлийн тухай хууль болон шинээр батлагдсан Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд захиргааны зөрчил болон эрүүгийн гэмт хэрэг хоорондын ялгааг тодорхой зохицуулсангүй, 14 жилийн өмнө тайланд дурдагдсан дээрх асуудал шийдэгдээгүй байна.

Хууль зүйн хариуцлага, захиргааны эрх зүйн зөрчил, хариуцлага, сахилгын зөрчил, хариуцлага, иргэний эрх зүйн зөрчил, хариуцлага зэргийг ялган зааглах, тодорхойлох шаардлагатай. Зөрчлийн хор уршиг, эрүүгийн гэмт хэргийн хор уршгийн ялгаа юу билээ? Гэтэл Зөрчлийн тухай хууль болон Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулиар захиргааны эрх зүйн зөрчил алга болж, Зөрчлийн тухай хуулийг Эрүүгийн хуулийн нэг хэсэг болгосон байна. Түүнчлэн 220, 230-аад хуульд байсан хариуцлагыг ЗӨВХӨН МЕХАНИКААР тусгасан нь хангалтгүй юм.

Академич С.Нарангэрэлтэй хийсэн ярилцлагын тэмдэглэлээс... 2018.11.19.

Мөн түүнчлэн Захиргааны хариуцлагын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 6 дахь хэсэг болон Монгол Улсын Дээд шүүхийн 2007 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн "Захиргааны хариуцлагын тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай" 45 дугаар тогтоол⁶-ын 4.5 дахь хэсэгт зааснаар "Иргэний байцаан шийтгэх хууль" гэдгийг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль гэж ойлгож зөрчлийн хэргийг Иргэний хэргийн шүүх Захиргааны хэргийн шүүхүүд харьяалан шийдвэрлэдэг байжээ.

Харин Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 2.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг болон 7.6 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт тус тус зааснаар дараах 17 эрх бүхий албан тушаалтны гаргасан шийтгэл оногдуулсан шийдвэрийг Захиргааны хэргийн шүүх хянан шийдвэрлэнэ⁷. Үүнд:

- Гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч;
- Мэргэжлийн хяналтын улсын байцаагч;
- Гаалийн улсын байцаагч;
- Татварын улсын байцаагч;

⁴ Захиргааны хариуцлагын тухай хуультай холбоотой судалгаа, Хууль зүйн үндэсний хүрээлэн, УБ., 2004, 1 дэх тал.

⁵ Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн танилцуулга, Хууль зүй, дотоод хэргийн яам, УБ., 2016, <http://mojha.gov.mn/images/files/huuliintusul/2016/z-Taniltuulga.pdf> (сүүлд үзсэн 2018.11.15.).

⁶ "Захиргааны хариуцлагын тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай" Монгол Улсын Дээд Шүүхийн тогтоол, 2007, №45. <http://www.supremecourt.mn/act/view/130> (сүүлд үзсэн 2018.11.12.).

⁷ Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 2.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан буюу Захиргааны хэргийн шүүхэд харьяалуулснаас бусад зөрчлийн хэргийг Эрүүгийн хэргийн шүүх шийдвэрлэнэ.

- Оюуны өмчийн улсын байцаагч;
- Нийгмийн даатгалын байцаагч;
- Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын улсын байцаагч;
- Гал түймрийн улсын хяналтын байцаагч;
- Санхүүгийн зохицуулах хорооны хянан шалгагч;
- Монголбанкны хянан шалгагч;
- Улсын бүртгэлийн хяналтын улсын байцаагч;
- Архив, албан хэрэг хөтлөлтийн хяналтын улсын байцаагч;
- Нягтлан бодох бүртгэлийн улсын байцаагч;
- Статистикийн улсын байцаагч;
- Нислэгийн аюулгүй ажиллагааны хяналт хариуцсан байцаагч;
- Төмөр замын тээврийн улсын байцаагч;
- Улсын байцаагчийн эрхтэй байгаль хамгаалагч гэсэн албан тушаалтнууд

болно.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн үзэл баримтлалын “Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар” хэмээх гурав дахь хэсэгт “Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль батлагдсанаар зөрчилд хариуцлага хүлээлгэх эрх бүхий албан тушаалтны үйл ажиллагааг нэгдсэн байдлаар тогтоосноор иргэд, хуулийн этгээдийн эрх ашиг зөрчигдөх явдал арилна. Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны үндэслэл, журмыг хуулиар нарийвчлан зохицуулах нь эрх зүйт төр, хүмүүнлэг ардчилсан нийгмийг бэхжүүлэх үйлсэд томоохон хувь нэмэр болно.”⁸ гэжээ.

Гэвч Улсын Ерөнхий прокурорын 2017 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн А/54 дүгээр тушаалын хавсралтаар зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны эрх зүйн хэлбэрийн жагсаалтыг⁹ баталж, эрх бүхий албан тушаалтнаас үйлдэх тэмдэглэл, тогтоол, санал, хүсэлт, тайлбар, баталгааны маягтын загварыг баталснаас өөрөөр эрх бүхий албан тушаалтнаас шийтгэл ногдуулах шийдвэр гаргахдаа баримтлах зарчмыг Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд тусгайлан заагаагүй.

Гагцхүү Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.2 дугаар зүйлийн 1-д “Зөрчил шалган шийдвэрлэх хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Зөрчлийн тухай хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ” гэснийг ...захиргааны байгууллагын¹⁰ эрх бүхий албан тушаалтны зөрчил шалган шийдвэрлэж, зөрчлийн захиргааны акт гаргах ажиллагаа нь Монгол Улсын Үндсэн хуулиар тогтоосон үзэл зарчимд нийцсэн байхыг¹¹ тодорхойлсон заалт гэж үзэж болох юм.

Дээрх ерөнхий заалт болон Улсын Ерөнхий прокурорын тушаалыг эс тооцвол шийдвэр гаргахдаа баримтлах зарчмыг тусгаагүй, Захиргааны хэргийн шүүхэд харьяалуулсан захиргааны байгууллагын эрх бүхий албан тушаалтны шийдвэрлэх хэргийн харьяаллыг тогтоохдоо дээр дурдсанчлан “механикаар” хуульчлахдаа салбарын хуулийн уялдааг бүрэн нягтлаагүй нь дараах зохицуулалтаас харагдана.

⁸ Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн үзэл баримтлал, Хууль зүй, дотоод хэргийн яам, УБ., 2016, <https://www.mojha.gov.mn/images/files/huuliintusul/2016/Zurchil-process-Uzelbarimtlal-2016-10-29.pdf>, (сүүлд үзсэн 2018.11.15.).

⁹ Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны эрх зүйн хэлбэрийн жагсаалт, <http://www.prokuror.mn/p/36> (сүүлд үзсэн 2018.11.22.).

¹⁰ Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн шүүхийн харьяаллыг үзвэл албан тушаалын байдлыг нь үндэслэсэн байх бөгөөд Захиргааны хэргийн шүүхэд харьяалуулсан 17 эрх бүхий албан тушаалтнууд нь Захиргааны ерөнхий хуулийн 5 дугаар зүйлд заасан “Захиргааны байгууллага”-ын албан хаагчид болно.

¹¹ Захиргааны ерөнхий хууль болон Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль ба Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, хэрэгцээ, шаардлага, гадаад орны туршлага судлах судалгааны тайлан, “Оюуны-Инноваци” ТББ, УБ., 2018, 26 дахь тал.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 2.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг болон 7.6 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт тус тус зааснаар “мэргэжлийн хяналтын улсын байцаагч”-ийн шийтгэл оногдуулсан шийдвэрийг Захиргааны хэргийн шүүх хянан шийдвэрлэдэг. Ингэхдээ мөн хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.10-д мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн шалган шийдвэрлэх зөрчлүүдийг Зөрчлийн тухай хуулийг эш татах замаар зааж өгсөн. Тэдгээрийн нэг нь болох Зөрчлийн тухай хуулийн 6.1 дүгээр зүйлд заасан “Хог хаягдлын тухай хууль” зөрчсөн зөрчлийг шалган шийдвэрлэнэ. Гэвч салбарын хууль болон Зөрчлийн тухай хууль хооронд дараах давхардал байна.

Зөрчлийн тухай хууль	Хог хаягдлын тухай хууль ¹²
6.1 дүгээр зүйл.Хог хаягдлын тухай хууль зөрчих	43 дугаар зүйл. Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага
1.Хог хаягдлыг зориулалтын цэгээс бусад газарт хаясан бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг гучин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.	43.1.Хог хаягдлын тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол улсын байцаагч, цагдаа болон сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга дараахь хариуцлага хүлээлгэнэ:
2.Хог хаягдлыг ил задгай шатаасан бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.	43.1.5.энэ хуулийн 10.3.3, 10.3.4-т заасныг зөрчсөн хүнийг тавин мянган төгрөгөөр, хуулийн этгээдийг дөрвөн зуун мянган төгрөгөөр торгох;
	43.1.6.энэ хуулийн 10.3.5-д заасныг зөрчсөн хүнийг тавин мянган төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр зуун мянган төгрөгөөр торгох;
	10.3.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад хог хаягдалтай холбоотой дараахь үйл ажиллагааг хориглоно:
	10.3.3.хог хаягдлыг ил задгай шатаах;
	10.3.5.хог хаягдлыг хогийн сав болон тогтоосон цэгээс бусад газарт хаях;

Дээрхээс үзвэл үйлдэх зөрчил нь адил атлаа хүлээлгэх хариуцлагын хэмжээ болон эрх бүхий албан тушаалтан ялгаатай байна.

– Хог хаягдлыг зориулалтын цэгээс бусад газар хаясан тохиолдолд Зөрчлийн тухай хуулийн дагуу мэргэжлийн хяналтын улсын байцаагч нь хүнийг 30,000₮/гучин мянга/-өөр, хуулийн этгээдийг 300,000₮ /гурван зуун мянга/-өөр тус тус торгож, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн дагуу шийтгэл оногдуулсан шийдвэр гаргах бол Хог хаягдлын тухай хуулийн дагуу улсын байцаагч, цагдаа болон сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга нар нь хүнийг 50,000₮ /тавин мянга/-өөр, хуулийн этгээдийг 200,000₮ /хоёр зуун мянга/-өөр торгож, Захиргааны ерөнхий хуулийн дагуу ердийн журмаар захиргааны акт тус тус гаргахаар байна.

– Хог хаягдлыг ил задгай шатаасан тохиолдолд Зөрчлийн тухай хуулийн дагуу мэргэжлийн хяналтын улсын байцаагч нь хүнийг 50,000₮ /тавин мянга/-өөр, хуулийн этгээдийг 500,000₮ /таван зуун мянга/-өөр тус тус торгож Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн дагуу шийтгэл оногдуулсан шийдвэр гаргах бол Хог хаягдлын тухай хуулийн дагуу улсын байцаагч, цагдаа болон сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга нар нь хүнийг 50,000₮ /тавин мянга/-өөр, хуулийн этгээдийг 400,000₮ /дөрвөн зуун мянга/-өөр тус тус торгож, Захиргааны ерөнхий хуулийн дагуу ердийн журмаар захиргааны акт тус тус гаргахаар байна.

¹² Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2017, №21.

Хэдийгээр хууль тогтоогчоос Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль батлагдсанаар "...хариуцлага хүлээлгэх эрх бүхий албан тушаалтны үйл ажиллагааг нэгдсэн байдлаар тогтоосноор иргэд, хуулийн этгээдийн эрх ашиг зөрчигдөх явдал арилна" хэмээн тодорхойлсон боловч дээр дурдсан шиг нэг үйлдэлд буюу адил тохиолдолд салбарын холбогдох хуулиар Захиргааны ерөнхий хуулийн дагуу ердийн журмаар захиргааны акт гаргах эсхүл Зөрчлийн тухай хуулиар Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу шийтгэл оногдуулсан шийдвэр гаргахын алийг хэрэглэх нь тодорхойгүй; мөн өөр өөр захиргааны байгууллага, албан тушаалтнууд хүн, хуулийн этгээдэд ялгаатай хариуцлага ногдуулахаар зохицуулсан нь иргэд, хуулийн этгээдийн эрх ашиг зөрчигдөх явдлыг арилгахгүй, харин ч нэмэгдүүлэхээр байна. Түүнчлэн энэ асуудлаас болж Захиргааны хэргийн шүүхэд маргаан шийдвэрлэх процесс хүндрэлтэй болж байна.

б) *Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль батлагдахаас өмнө болон батлагдсанаас хойш зөрчлийн хэргийг Захиргааны хэргийн шүүхээр шийдвэрлэж буй асуудал, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн уялдаа:*

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 2.1 дүгээр зүйлд зөрчлийг хянан шийдвэрлэх шүүхүүдийг зааж, эрх бүхий албан тушаалтны албан тушаалын байдал, харьяаллыг үндэслэн тус бүрийн гаргасан шийтгэл оногдуулсан шийдвэрийг Эрүүгийн хэргийн шүүх, Захиргааны хэргийн шүүхийн аль нь шийдвэрлэхийг заасан. Энэ хэсэгт мөнхүү зохицуулалтын 2 дахь хэсэгт зарим зөрчлийн хэргийг Захиргааны хэргийн шүүх хянан шийдвэрлэх; 7.6 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт Захиргааны хэргийн шүүх үйл ажиллагаандаа Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийг хэрэглэхээр тус тус хуульчилсан заалтууд нь зорилгодоо хүрсэн эсэх, ямар үндэслэлээр шүүхийн харьяаллыг тогтоосныг тодруулах зорилготой.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль батлагдахаас өмнө Захиргааны хэргийн шүүх зөрчлийн хэргийг ердийн журмаар шийдвэрлэдэг буюу "шүүх нотлох зарчмыг хэрэгжүүлэх", нөгөө талаас хэргийн оролцогчид "мэтгэлцэх зарчим"-ыг хэрэгжүүлэх боломж нь бүрэн нээлттэй байсан. Гэтэл Улсын Их Хурлаас Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийг батлахдаа Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд дараах нэмэлт, өөрчлөлтийг¹³ оруулсан.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль	
Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль батлагдахаас өмнөх бичвэр	Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль батлагдсаны дараах бичвэр
7.1. Захиргааны хэргийн шүүх хэргийн нөхцөл байдлыг тодруулах, хэргийг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий нотлох баримт цуглуулах, үнэлэх ажиллагааг хэрэгжүүлэх үүрэгтэй бөгөөд хэргийн оролцогчийг татан оролцуулна.	7.1. Захиргааны хэргийн шүүх хэргийн нөхцөл байдлыг тодруулах, хэргийг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий нотлох баримт цуглуулах, үнэлэх ажиллагааг хэрэгжүүлэх үүрэгтэй бөгөөд хэргийн оролцогчийг татан оролцуулна.
7.2. Шүүх нотлох зарчмыг хэрэгжүүлэх нь хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгчийн хэрэгт ач холбогдол бүхий нотлох баримт гаргаж өгөх, энэ талаар хүсэлт гаргах эрхийг хязгаарлахгүй.	7.2. Шүүх нотлох зарчмыг хэрэгжүүлэх нь хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгчийн хэрэгт ач холбогдол бүхий нотлох баримт гаргаж өгөх, энэ талаар хүсэлт гаргах эрхийг хязгаарлахгүй.
	7.3. Энэ зүйлийн 7.1, 7.2 дахь хэсэгт заасан зарчим нь гомдол хянан шийдвэрлэх ажиллагаанд хамаарахгүй.
	112.9. Шүүх гомдол хянан шийдвэрлэх ажиллагааны явцад нэмэлт нотлох баримт цуглуулахгүй.

¹³ "Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" хууль, 2017, <https://www.legalinfo.mn/additional/details/3171?lawid=11703> (сүүлд үзсэн 2018.10.25.).

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль батлагдахаас өмнө Захиргааны хэргийн шүүх нь хэргийн оролцогчдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хангах үүднээс захиргааны хэргийн хүрээнд “шүүх нотлох зарчим”-ыг хэрэгжүүлдэг, хэргийн оролцогчдын зүгээс ч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хүсэлт гаргах, шийдвэрлүүлэх, нэмэлт нотлох баримт гаргах, гаргуулах тухай хүсэлт гаргах, шүүх хуралдаанд биечлэн оролцож өөрсдийн үндэслэлийг зөвтгөх буюу эсрэг талын тайлбарыг няцаах бүрэн боломжтой байсан бол Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль батлагдсанаар Захиргааны хэргийн шүүх нь Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд “шүүх нотлох зарчим”-ыг хэрэглэхгүй, нэмэлт нотлох баримт цуглуулахгүй болсон бөгөөд энэ нь захиргааны эрх зүйн онол, зарчим хийгээд Захиргааны хэргийн шүүхийн үндсэн чиг үүргийн үүднээс ихээхэн эргэлзээ, маргаантай байдлыг үүсгэсэн байна.

Тухайлбал, өмнөх хэсэгт дурдсан “Хог хаягдлын тухай хууль” болон Зөрчлийн тухай хуульд адил тохиолдолд хүлээлгэх хариуцлага болон шийдвэрлэх албан тушаалтныг ялгаатай зохицуулснаас үүдэн нөхцөл байдал мөн өөрчлөгдөнө. Хог хаягдлын тухай хуульд заасныг зөрчсөн гэж үзвэл хүн, хуулийн этгээдэд захиргааны эрх бүхий албан тушаалтан тус хуулийн дагуу шийтгэл оногдууллаа гэхэд түүнийг нь үндэслэлгүй гэж үзсэн, эс зөвшөөрсөн холбогдох этгээд Захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргаж, шүүхийн зүгээс Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан журмын дагуу хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах буюу “шүүх нотлох зарчим”-ын дагуу шаардлагатай ажиллагааг хийж, хүн, хуулийн этгээдийг эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хангах бүрэн боломжтой. Гэтэл Зөрчлийн тухай хуульд зааснаар мэргэжлийн хяналтын улсын байцаагч шийтгэл оногдуулах шийдвэр гаргасан тохиолдолд түүнийг нь эс зөвшөөрсөн хүн, хуулийн этгээд Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд зааснаар Захиргааны хэргийн шүүхэд хандах эрх нь нээлттэй боловч “шүүх нотлох зарчим” хэрэгжихгүй, нэмэлт нотлох баримт цуглуулахгүй тул хэргийн оролцогчийн эрх, хууль ёсны ашиг сонирхол бүрэн утгаараа хэрэгжих боломжгүй байна. Ийнхүү адил тохиолдолд ялгаатай байдлаар шийдвэрлэхээр байгаа нь асуудал үүсгэж байна.

Орчин үеийн захиргааны шүүхийн зорилго, чиг үүргийг дараах байдлаар тодорхойлдог.¹⁴

- Захиргааны хууль бус үйл ажиллагаанаас иргэний эрхийг хамгаалах буюу субъектив эрхийн хамгаалалт болох;
- Захиргаанаас хууль ёсыг сахих хөшүүрэг нь болох буюу объектив эрхийн хамгаалалтыг бий болгоход оршдог.

Өөрөөр хэлбэл, захиргааны хэргийн шүүхийн чиг үүрэг, зорилго нь өөрийн санаачилгаар захиргааг цаг ямагт хянах буюу дээд шатны захиргааны байгууллага шиг байх (general control = ерөнхий хяналт) бус харин захиргааны хууль бус үйл ажиллагаанаас иргэний эрх, хууль ёсны ашиг сонирхол хөндөгдсөн гэх тохиолдолд магадлах ажиллагаа (judicial review) хэрэгжүүлж, иргэн, хуулийн этгээдийн эрх зөрчигдсөн тохиолдолд хамгаалах, сэргээн тогтоох явдал байдаг.¹⁵

Тиймдээ ч Захиргааны хэргийн шүүхийн үйл ажиллагааны гол зарчим бол “шүүх нотлох зарчим” буюу “мөрдөн шалгах зарчим”¹⁶ юм. Захиргааны хэргийн нотлох баримт цуглуулах үүргийг Захиргааны хэргийн шүүх гүйцэтгэх нь хэргийн

¹⁴ Г.Банзрагч, “Эрх зүйт төр буюу захиргааны хэргийн шүүх”, 2014, Хууль зүйн судалгааны бүтээлийн цахим сан, <http://legaldatal.mn/buteel/pdf?id=249> (сүүлд үзсэн: 2018.11.01.).

¹⁵ Захиргааны ерөнхий хууль болон Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль ба Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, хэрэгцээ, шаардлага, гадаад орны туршлага судлах судалгааны тайлан, “Оюуны-Инноваци” ТББ, УБ., 2018, 53 дахь тал.

¹⁶ Доктор, дэд профессор А.Эрдэнэцогт өөрийн бүтээлдээ “Inquisitionsmaxime” /rep./ буюу “шүүх нотлох зарчим”-ыг “мөрдөн шалгах зарчим” хэмээх нэршлээр орчуулсан.

оролцогчдын эрх тэгш байдлыг хангах зорилготой. Учир нь захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогчдын нэг талд иргэн, нөгөө талд захиргаа оролцох нь гарааны нөхцөлийн хувьд тэгш биш байх тул процессын хүрээнд тэдгээрийн тэгш байдлыг хангах гол арга зам нь хэргийн нотлох баримт цуглуулах үүргийг талуудад найдан орхих бус, харин Захиргааны хэргийн шүүхэд хуулиар хүлээлгэх нь зохимжтой. Энэ утгаараа мөрдөн шалгах зарчим нь тэгш байдлын зарчимтай шүтэлцдэг бөгөөд харилцан уялдаатай хэрэгждэг.¹⁷

Гэтэл Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуультай холбогдуулан нэмэлт, өөрчлөлт оруулахдаа зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд Захиргааны хэргийн шүүхийн “шүүх нотлох зарчим” хэрэгжихгүй байхаар хуульчилсан нь “... Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасан хохирогч, холбогдогч, тэдгээрийн хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч зэрэг зөрчлийн хэрэгт оролцогчдын “зөрчил шалгах тодорхой ажиллагаа явуулах хүсэлт гаргах, нотлох баримт шалгуулах тухай хүсэлт гаргах, нотлох баримт гаргаж өгөх” ...эрхүүд бодитой хэрэгжих нөхцөл үгүй болж, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны явцад эрх бүхий албан тушаалтны гаргасан зөрчлийн захиргааны актад тавих шүүхийн хяналтыг *хэлбэрийн төдий* болгосон¹⁸ байх бөгөөд эдгээрээс үүдээд шүүхийн харьяаллыг тодорхойлсон 2.1 дүгээр зүйлийн 2, Захиргааны хэргийн шүүхийн хэрэглэх хуулийг тодорхойлсон 7.6 дугаар зүйлийн 2 дахь зохицуулалтын учир шалтгаан тодорхой бус, зорилгодоо хүрээгүй гэж дүгнэх үндэслэлтэй байна.

Ийнхүү дээр дурдсан үндэслэл, шалтгааны улмаас Захиргааны хэргийн шүүхийн практикт Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн дагуу зөрчлийн хэргийг хянан шийдвэрлэхэд хүндрэлтэй байна. Тиймээс дурдагдсан асуудлаар Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхээс 2018 оны 2 дугаар сарын 7-ны өдөр “Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлж, Улсын дээд шүүхэд санал гаргах тухай” 85 дугаар тогтоолыг¹⁹ гаргасан бөгөөд “...Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны зарчим, журам нь шүүхийн өмнө эрх тэгш байх, эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулах, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх, хүний эрх, эрх чөлөөг хангахуйц... хууль зүйн... баталгааг бүрдүүлэх Үндсэн хуулийн баталгааны хэрэгжилтийг харуулах гол шалгуур үзүүлэлт юм. Гэтэл захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны гол зарчмууд болох шүүх нотлох, мэтгэлцэх зарчмууд захиргааны хэргийн шүүхээс гомдол хянан шийдвэрлэх ажиллагааны дагуу хянах хэргийн... хувьд хэрэгжих боломжгүй байгаа нь хэргийн оролцогчдын Үндсэн хуулиар хамгаалагдсан эрх, баталгаа хангагдахгүй нөхцөлд хүргэж байна.

Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулиар дамжуулан Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд шинээр бий болгосон гомдол хянан шийдвэрлэх ажиллагаа нь хянан шийдвэрлэх ажиллагаа нэршилтэй боловч шүүхээс бодит байдлаар хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах боломжгүй, хэлбэрийн хувьд шүүх хянан шийдвэрлэж байгаа мэт, шүүх хянасан гэх нэр төдий процесс болоход хүрч байна”²⁰ хэмээжээ.

¹⁷ А.Эрдэнэцогт, Захиргааны процессын эрх зүй, 2 дахь хэвлэл, УБ., 2014, 28 дахь тал.

¹⁸ “Захиргааны ерөнхий хууль болон Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль ба Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, хэрэгцээ, шаардлага, гадаад орны туршлага судлах” судалгааны тайлан, “Оюуны-Инноваци” ТББ, УБ., 2018, 37 дахь тал.

¹⁹ “Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлж, Улсын дээд шүүхэд санал гаргах тухай”, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн тогтоол, №85, (2018.02.07).

²⁰ Мөн тэнд.

Энэхүү саналын дагуу Монгол Улсын Дээд шүүх Үндсэн хуулийн цэцэд²¹ “... Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.11 дэх заалтын холбогдох хэсэг, 7 дугаар зүйлийн 7.3, 112 дугаар зүйлийн 112.9 дэх хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн талаар” хүсэлт гаргасан ба Үндсэн хуулийн цэцэд маргаан үүсгэн шийдвэрлэх явц үргэлжилж байна.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд зөрчлийн зарим хэргийг Захиргааны хэргийн шүүхэд харьяалуулан хуульчилсантай холбоотойгоор Захиргааны хэргийн шүүхийн үйл ажиллагаандаа баримтлах процессын хууль болох Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахдаа “шүүх нотлох зарчим”-ыг зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд хэрэгжихгүй болгосноор иргэн, хуулийн этгээд эрх, хууль ёсны ашиг сонирхол хангагдах бус харин зөрчигдөхөд хүрч буй бөгөөд Захиргааны хэргийн шүүхийн үндсэн чиг үүрэг, зорилгыг “гажуудуулж”, улмаар Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 2.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг болон 7.6 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг хуульчилсан үндэслэл; зөрчлийн зарим хэргийг Захиргааны хэргийн шүүхэд харьяалуулсан нь маргаантай байдлыг үүсгэсэн байна.

3.2. “Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал

Шалгуур үзүүлэлтийн томъёолол 1. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 4.8 дугаар зүйл буюу мэдүүлэг авах зохицуулалт практикт нийцэж байна уу?

Үнэлэх зүйл, заалт	4.8 дугаар зүйл. Мэдүүлэг авах 1. Эрх бүхий албан тушаалтан зөрчил гарсан байдлыг тодруулах, зөрчил шалган шийдвэрлэхэд ач холбогдол бүхий баримт, мэдээллийг олох зорилгоор мэдүүлэг авна. 2. Мэдүүлгийг тухайн хүнийг эрх бүхий байгууллагад ирүүлэн, эсхүл тухайн хүний байгаа газарт авч болно. 4. Эрх бүхий албан тушаалтан хүнийг албадан ирүүлэх, өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг /эх/, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхийг шаардах эрхгүй.
--------------------	---

Үнэлгээ: Эрх бүхий албан тушаалтан зөрчил гарсан байдлыг тодруулах, зөрчил шалган шийдвэрлэхэд ач холбогдол бүхий баримт, мэдээллийг олох зорилгоор мэдүүлгийг авч байна.

Уг зүйлийн 2 дахь хэсэгт “Мэдүүлгийг тухайн хүнийг эрх бүхий байгууллагад ирүүлэн, эсхүл тухайн хүний байгаа газарт авч болно” хэмээн заасны дагуу үйл ажиллагаа явагдаж байна.

Гэвч дээрх заалт хууль хэрэгжиж эхэлсэн эхэн үед хэрэгжиж байсан боловч зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны зарим нэг зохицуулалт дутмаг байгаагаас зөрчил гаргасан хүн дуудсан хугацаанд ирэхгүй, тухайн хүний байгаа газарт мэдүүлэг авахаар очиход эзгүй байх, зөрчлийн холбогдогч хаана байгаа нь тогтоогдохгүй, холбоо барих боломжгүй болох зэргээс шалтгаалж зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа удаашрах, зарим тохиолдолд хэрэг бүртгэлтийн хугацаа дууссан гэсэн үндэслэлээр зөрчлийн хэрэг хэрэгсэхгүй болгох тохиолдол гардаг байна.

Уг зүйлийн 4 дэх хэсэгт “Эрх бүхий албан тушаалтан хүнийг албадан ирүүлэх, өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг /эх/, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхийг шаардах эрхгүй” хэмээн хуульчилсан.

²¹ “Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргах тухай”, Улсын дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдааны тогтоол, №02, (2018.04.19).

Эрх бүхий албан тушаалтан зөрчил гарсан байдлыг тодруулах, зөрчил шалган шийдвэрлэхэд ач холбогдол бүхий баримт, мэдээллийг олох зорилгоор мэдүүлэг авахдаа “эрх бүхий албан тушаалтан хүнийг албадан ирүүлэхгүй” байхаар заажээ.

Судалгааны явцад практикт зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа хуульд заасан үндэслэл, журмын дагуу явагдаж байгаа хэдий ч энэхүү хуульд зарим нэг зохицуулалт дутмаг /албадлага хэрэглэх заалт/ байгаа нь хэргийн тал бүрээс бүрэн бодитой тогтоох, цаашлаад хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааг удаашруулахад хүргэж байгаа нь ажиглагдсан. Тухайлбал, Зөрчлийн холбогдогч нь мэдүүлэг авахаар дуудахад ирэхгүй байх, оргон зайлсан тохиолдолд энэ хуулиар авах арга хэмжээний талаар тусгаагүй учраас хэрэг шийдвэрлэгдэхгүй, хугацаа сунгагддаг байна.

Иймд судалгаанд оролцогчдын зүгээс зөрчлийн холбогдогч хаана байгаа нь тогтоогдохгүй, дуудсан хугацаанд ирдэггүй нь зөрчил шалгах ажилд хүндрэл учруулж байгаа нь олон хэрэг шийдвэрлэхэд хугацаа алдахад хүргэж байна. Мөн эрэн сурвалжлах үндэслэл заагаагүй учраас зөрчил үйлдсэн этгээдийг эрэн сурвалжлах, зөрчлийг шийдвэрлэхэд хүндрэлтэй байдаг хэмээн үзэж байна.

Ийнхүү мэдүүлэг авах ажиллагаа хууль хэрэгжиж эхэлсэн үед хэрэгжиж байсан хэдий боловч хууль сахиулагчийн хийвэл зохих зан үйлийн процессууд нь бүрэн бус учир цаашид хуулийн хэрэгжилтэд хүндрэл үүсэхээр байна.

Иймд эрэн сурвалжлах ажиллагааны үндэслэл, шийдвэр гаргах эрх бүхий албан тушаалтныг тодорхой болгох нь чухал байна.

Шалгуур үзүүлэлтийн томъёолол 2. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 6.6 дугаар зүйл буюу хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлэх зохицуулалт практикт нийцэж байна уу?

Үнэлэх зүйл, заалт	6.6 дугаар зүйл.Хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлэх 1.Дараах үндэслэлийн аль нэг нь тогтоогдвол эрх бүхий албан тушаалтан зөрчлийг хялбаршуулсан журмаар шалган шийдвэрлэнэ: 1.1.зөрчил үйлдэгдсэн нь ил тодорхой, зөрчил, учирсан хохирлыг нотлох талаар зөрчлийн хэрэг бүртгэлт явуулах шаардлагагүй бол; 1.2.зөрчил үйлдэгдсэн, учруулсан хохирол нь нотлох баримтаар тогтоогдож холбогдогч зөрчил үйлдсэнээ сайн дураараа хүлээн зөвшөөрсөн бол; 1.3.зөрчил үйлдсэн болох нь стандартаар баталгаажсан хэмжилт-хяналтын төхөөрөмжөөр нотлогдсон бол. 2.Зөрчлийн хэрэг бүртгэлтийн явцад холбогдогч зөрчил үйлдсэнээ сайн дураараа хүлээн зөвшөөрсөн, эсхүл зөрчил үйлдсэн нь тогтоогдож байгаа бол эрх бүхий албан тушаалтан хуульд заасан шийтгэл оногдуулж, албадлагын арга хэмжээ авна. 3.Холбогдогчийг зөрчил үйлдсэн болохыг хүлээн зөвшөөрүүлэхээр тулган шаардах, албадахыг хориглоно. 4.Эрх бүхий албан тушаалтан хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлэж, шийтгэл оногдуулахдаа энэ хуулийн 7.1 дүгээр зүйлд заасан журмыг баримтална. 5.Эрх бүхий албан тушаалтан хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлэсэн даруй прокурорын нэгдсэн бүртгэлд бүртгүүлнэ.
--------------------	--

Үнэлгээ: Уг хуулиар хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлэх үндэслэлийг тогтоосон бөгөөд зөрчил шалгах ажиллагааг чирэгдэл, шат дамжлага багатай, богино хугацаанд шийдвэрлэх зохицуулалтыг тусгажээ. Зөрчил үйлдсэн нь ил тодорхой, зөрчил болон учирсан хохирлыг нотлох талаар ажиллагаа явуулах шаардлагагүй, эсхүл үйлдсэн зөрчил нь нотлох баримтаар батлагдсан бөгөөд зөрчил үйлдсэнээ сайн дураар хүлээн зөвшөөрсөн хүн, хуулийн этгээдэд холбогдох зөрчлийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэхээр заасан.

Гэхдээ хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлэхэд практикт шийдвэрлэвэл зохих хүндрэл тулгарч байна. Үүнд:

1. Энэхүү хуулийн 6.6 дугаар зүйлд заасан “хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлэх” үндэслэлд заасан нөхцөл байдал тогтоогдсон боловч газар дээр нь арга хэмжээ авах боломжгүй тохиолдол бий болдог байна. Жишээлбэл, Зөрчлийн тухай хуулийн 14.7 дугаар зүйлийн 3.2-т заасан “согтууруулах ундаа, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн эсэхийг зохих журмын дагуу шалгуулахаас зайлсхийсэн бол тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг нэг жилийн хугацаагаар хасаж хүнийг дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно” гэсэн ба эрх бүхий албан тушаалтан уг зөрчлийг гаргасан этгээдийн эрхийг газар дээр нь хасах боломжгүй байдал үүсдэг. Уг хэргийг шийдвэрлэхийн тулд эхлээд шаардлагатай лавлагаа мэдээллийг авсны үндсэнд шийдвэрлэх боломжтой бөгөөд энэ тохиолдолд хялбаршуулсан журмаар шалгасанд хамааруулах эсэх нь тодорхой бус байдлыг бий болгодог байна.

2. Уг хуулийн 6.6 дугаар зүйлийн дагуу хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлэх явцад гомдол гаргах эрхийг тусгаагүй нь хүний эрх зөрчигдөхөд хүргэж байна. Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны аль ч шатанд гомдол гаргах эрхтэй байхаар тусгах ёстой. Иймд энэхүү хуульд гомдол гаргах эрхийн тухай нэмж оруулах шаардлагатай байна.

3. Хууль зүйн сайдын 2015 оны А/188 тоот тушаалаар баталсан “Бэлэн бус хэлбэрээр торгууль оногдуулах журам”-д уг үйл ажиллагааг зохицуулсан боловч, тус журмаар тодорхой зохицуулалтыг хуульчилж өгөөгүйгээс бэлэн бус хэлбэрээр торгууль оногдуулах үйл ажиллагааг явуулахад бэрхшээлтэй байдаг байна. Энэ нь тээврийн хэрэгсэл ашиглаж үйлдсэн зөрчлийг хяналтын камераар баримтжуулсан хэдий ч заавал зөрчил гаргагчийг ирүүлэх, бэлэн бус торгуулийн төхөөрөмжөөс цахим хэлбэрээр шийтгэлийн хуудас хэвлэхэд заавал цаасан баримт давхар хөтлөхийг прокурор, шүүхээс шаардаж байгаа нь энэ төрлийн зөрчлийн илрүүлэлт болон шийдвэрлэлтэд хүндрэл үүсгэхүйц байдлыг бий болгодог байна.

Түүнчлэн хялбаршуулсан журмаар шалган шийдвэрлэх ажиллагааг хуулийн 6.6 дугаар зүйлд бэлэн бус хэлбэрээр торгууль оногдуулах зохицуулалтыг орхигдуулсан нь шийдвэрийн биелэлтийг эрх бүхий албан тушаалтан хариуцах нь практикт хэрэгжүүлэх боломж хомс байна. Энэ нь ялангуяа бага хэмжээний торгууль дээр ямар ч үр ашиггүйгээр илэрч байна. Тухайлбал, нэг аймгийн цагдаагийн ажилтан 10,000 төгрөгийн торгуулийг төлүүлэхээр нөгөө аймагруу томилолт авч очоод шүүхэд өгч шийдвэрлүүлэх шаардлага үүсдэг.²²

Иймд хялбаршуулсан журмаар шалган шийдвэрлэхдээ бэлэн бус хэлбэрээр торгууль оногдуулах хуулийн заалт, холбогдох журмын хэрэгжилтийг тодорхой болгох шаардлагатай байна.

4. Уг хуулийн Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулах үндэслэл /6.1 дүгээр зүйл/-ийн 2.3-т хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлэх гэж, харин Зөрчлийн тухай хуулийн 3.5 дугаар зүйл буюу баривчлах шийтгэлийн 2 дахь хэсэгт “баривчлах шийтгэлийг шүүгч оногдуулна” хэмээн тус тус хуульчилсан. Эндээс баривчлах шийтгэлтэй зөрчилд заавал зөрчлийн хэрэг нээж зөрчлийн хэрэг бүртгэлтийн ажиллагаа явуулж шүүхэд шилжүүлэх, аль эсхүл хялбаршуулсан журмаар зөрчлийг шалгаад шүүхэд шилжүүлэх эсэх нь тодорхойгүй байна.

²² “Хуулийн шүүмж”, Нээлттэй нийгэм форум, УБ., 2018, №24.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ**4.1. Дүгнэлт**

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлангийн хүрээнд холбогдох зохицуулалтыг сонгон авч үнэлсний үндсэн дээр дараах дүгнэлтэд хүрч байна.

Зорилгод хүрсэн байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 2.1 дүгээр зүйл.Зөрчил хянан шийдвэрлэх шүүх; 7.6 дугаар зүйл.Шийтгэл оногдуулсан шийдвэрт гомдол гаргах

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд тус заалтуудыг оруулсантай холбоотойгоор Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан ба ингэхдээ Захиргааны хэргийн шүүхийн “шүүх нотлох зарчим”-ыг Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд хэрэгжихгүй болгосноор Захиргааны хэргийн шүүхийн үндсэн чиг үүрэг, зорилго хумигдаж байх төдийгүй иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдөхөд хүрч байна. Мөн хууль тогтоогчоос Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийг батлахдаа салбарын бусад хууль тогтоомжийг уялдааг бүрэн нягтлаагүй, механикаар хуульчилсны улмаас шүүхийн үйл ажиллагаанд хүндрэл учрах, хууль хэрэглэх ажиллагаанд маргаантай байдлыг үүсгэж байна.

Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд Захиргааны хэргийн шүүх “шүүх нотлох зарчим”-ыг хэрэгжүүлэхгүй, нэмэлт нотлох баримт цуглуулахгүй, гагцхүү зөрчлийн хавтаст хэрэгт авагдсан материалын хүрээнд хэргийг шийдэх нь учир дутагдалтай бөгөөд Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн дагуу үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх боломжгүй байгаа нь үнэлгээний хүрээгээр сонгож авсан тус зохицуулалтууд зорилгодоо хүрээгүй байна гэж дүгнэлээ.

Практикт нийцэж байгаа байдал:

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 4.8 дугаар зүйл.Мэдүүлэг авах

Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа хуульд заасан үндэслэл, журмын дагуу явагдаж байгаа хэдий ч энэхүү хуульд зарим нэг зохицуулалт дутмаг /албадлага хэрэглэх заалт/ байгаа нь хэргийг тал бүрээс бүрэн бодитой тогтоох, цаашлаад хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааг удаашруулахад хүргэж байна. Энэ байдал нь зөрчлийн холбогдогч нь мэдүүлэг авахаар дуудахад ирэхгүй байх, оргон зайлсан тохиолдолд энэ хуулиар авах арга хэмжээний талаар хуульд тусгаагүй учраас хэрэг шийдвэрлэгдэхгүй, хугацаа сунгагддаг байна. Мөн эрэн сурвалжлах үндэслэл заагаагүй учраас зөрчил үйлдсэн этгээдийг эрэн сурвалжлах, зөрчлийг шийдвэрлэхэд хүндрэлтэй байдаг байна.

Ийнхүү мэдүүлэг авах ажиллагаа хууль хэрэгжиж эхэлсэн үед хэрэгжиж байсан хэдий боловч зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг нарийвчлан тусгаж өгөөгүй учир цаашид хуулийн хэрэгжилтэд хүндрэл үүсэхээр байна.

6.6 дугаар зүйл.Хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлэх

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 6.6 дугаар зүйлийн дагуу хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлэх явцад гомдол гаргах эрхийг тусгаагүй нь хүний эрх зөрчигдөхөд хүргэж байна.

Хялбаршуулсан журмаар шалган шийдвэрлэх ажиллагааг хуулийн 6.6 дугаар зүйлд бэлэн бус хэлбэрээр торгууль оногдуулах зохицуулалтыг орхигдуулсан нь шийдвэрийн биелэлтийг эрх бүхий албан тушаалтан хариуцах нь практикт хэрэгжүүлэх боломж хомс байна.

Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулах үндэслэл /6.1 дүгээр зүйл/-ийн 2.3-т хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлэх гэж, харин Зөрчлийн тухай хуулийн 3.5 дугаар зүйл буюу баривчлах шийтгэлийн 2 дахь хэсэгт “баривчлах

шийтгэлийг шүүгч оногдуулна” хэмээн тус тус хуульчилсан. Эндээс баривчлах шийтгэлтэй зөрчилд заавал зөрчлийн хэрэг нээж зөрчлийн хэрэг бүртгэлтийн ажиллагаа явуулж шүүхэд шилжүүлэх, аль эсхүл хялбаршуулсан журмаар зөрчлийг шалгаад шүүхэд шилжүүлэх эсэх нь тодорхойгүй байна.

4.2. Зөвлөмж

Үнэлгээний ажлын хүрээнд хийсэн үнэлгээ, дүгнэлтийг үндэслэн дараах зөвлөмжийг гаргаж байна. Үүнд:

- Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль болон бусад салбарын хууль тогтоомжийн уялдаа холбоог хангах, тэдгээртэй холбогдон үүссэн давхардлыг арилгах, Зөрчлийн тухай хуульд тодорхой зөрчлүүдийг “механикаар” хуульчилсан алдааг (үүнээс үүдэн Захиргааны хэргийн шүүх нь Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн дагуу зөрчлийн хэргийг шийдвэрлэх эсхүл Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дагуу ердийн журмаар шийдвэрлэхийн аль нь болох талаар эргэлзээтэй асуудал үүсэж байх тул) залруулах;

- Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийг батлахтай холбогдуулан Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг буюу Улсын Их Хурлаас 2017 оны 5 дугаар сарын 18-ны өдөр баталсан “Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийг хүчингүй болгох, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд “шүүх нотлох зарчим”-ыг хэрэгжүүлэх боломжоор хангах шаардлагатай;

- Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг нарийвчлан тусгаж өгөх;

- Эрэн сурвалжлах ажиллагааны үндэслэл, шийдвэр гаргах эрх бүхий албан тушаалтныг тодорхой болгох;

- Хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлэх энэ хэсэгт гомдол гаргах эрх байхгүй. Энэ хуулийн 1.12 дугаар зүйлд гомдол гаргах эрхийн тухай нэмж оруулах;

- Хялбаршуулсан журмаар шалган шийдвэрлэхдээ бэлэн бус хэлбэрээр торгууль оногдуулах хуулийн заалт, холбогдох журмын хэрэгжилтийг тодорхой болгох шаардлагатай байна;

- Зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтнуудад зөрчлийн тухай хууль тогтоомж, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны талаарх эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, шинэ эрх зүйн орчинд ажиллах чиглэлээр сургалтуудыг тогтмол зохион байгуулах зэрэг болно.

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

Нэг. Хууль тогтоомж

- Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, УБ., 2015, №28.
- Захиргааны хариуцлагын тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, УБ., 1992, №4-5.
- Захиргааны ерөнхий хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, УБ., 2015, №28.
- Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, УБ., 2016, №9.
- Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, УБ., 2017, №24.
- Зөрчлийн тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, УБ., 2017, №24.
- Хог хаягдлын тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, УБ., 2017, №21.

- “Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 8.2 дугаар зүйлийн 8 дахь хэсэг, 9.2 дугаар зүйлийн 13 дахь хэсэг нь Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай дүгнэлт”, Үндсэн Хуулийн Цэцийн дүгнэлт, (2018.06.16) №09.

- “Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлж, Улсын дээд шүүхэд санал гаргах тухай”, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн тогтоол, (2018.02.07) №85.

- Улсын дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдааны тогтоол, (2018.04.19) №02.

Хоёр. Ном, гарын авлага, судалгааны тайлан

- Захиргааны ерөнхий хууль болон Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль ба Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, хэрэгцээ, шаардлага, гадаад орны туршлага судлах судалгааны тайлан, “Оюуны-Инноваци” ТББ, УБ., 2018 он.

- Монгол Улсын хууль-Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, сургагч багш нарт зориулсан гарын авлага, Хууль зүй, дотоод хэргийн яам, УБ., 2017 он.

- Монгол Улсын Захиргааны ерөнхий хуулийн тайлбар, Ханнс-Зайделийн сан, УБ., 2017 он.

- Хуулийн шүүмж, Нээлттэй нийгэм форум, УБ., 2018, №24.

Гурав. Илтгэл, өгүүлэл

- Банзрагч.Г “Эрх зүйт төр буюу захиргааны хэргийн шүүх” (2014) Хууль зүйн судалгааны бүтээлийн цахим сан, <http://legaldata.mn/buteel/pdf?id=249>

- Цогт.Ц. “Захиргааны эрх зүй дэх “хууч хамаарал” буюу прокурорын хяналт” (2017) Хууль зүйн судалгааны бүтээлийн цахим сан, <http://legaldata.mn/b/387>

Дөрөв. Цахим эх сурвалж

- <http://www.legalinfo.mn/> - Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем.

- <http://forum.parliament.mn/projects/87> - Монгол Улсын Их Хурал, цахим хэлэлцүүлгийн хуудас /ЗШШТХ-д холбогдох хавсралтууд/.

- <http://conscourt.gov.mn> – Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн албан ёсны цахим хуудас.

- <http://www.shuukh.mn> – Монгол Улсын шүүхийн шийдвэрийн цахим сан.

- <http://mojha.gov.mn/> - Хууль зүй, дотоод хэргийн яамны албан ёсны цахим хуудас.

- <http://www.nli.gov.mn/> - Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн албан ёсны цахим хуудас.

- <http://www.legaldata.mn/> - Хууль зүйн судалгааны бүтээлийн цахим сан.

---oOo---